



**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ХУРАЛДААН**  
Аймгийн ИТХ-ын VI удаагийн сонгуулийн ээлжит XI хуралдаан 2016 оны 05-р сарын 20-нд хуралдлаа. Хуралдаанаар дараах 6 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Үүнд:

1. Аймгийн ИТХ-ын 2012-2016 оны үндсэн чиглэл, түүний хэрэгжилт, үр дүн
2. Улаангом хотын ерөнхий төлөвлөгөө батлах тухай
3. Улаангом сумын нутаг дэвсгэр дэх /орон сууц, гэр хороолол/ дахин төлөвлөлтийн тухай, газар зохион байгуулалтын 2016 оны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай
4. 2016 оны төсвийн тодотголын тухай
5. Концессийн зүйлийн жагсаалтанд нэмэлт өөрчлөлт оруулах, 2017 оны орон нутгийн төсөвт хөрөнгө тусгах тухай
6. Малын зах ажиллуулах үйл ажиллагааны журам батлах тухай



**ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХУРАЛ**



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал V сарын 02, 18-ны өдрүүдэд 2 удаа хуралдан аймаг, орон нутгийн хэмжээнд тулгамдсан

нийт 18-н асуудлыг авч хэлэлцэн шийдвэрлэж холбогдох тогтоол, тэмдэглэлүүдийг гарган ажиллалаа.

**УВС АЙМАГТ “НИЙГМИЙН ЭГЭХ ХАРИУЦЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ” ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛАХ СЕМИНАР БОЛЛОО.**

“Монгол Улсад Нийгмийн Эгэх Хариуцлагыг Бэхжүүлэх төсөл”-ийн танилцуулга семинар аймгийн ЗДТГ-ын “Иргэний оролцоо” хуралдааны танхимд боллоо.

Нийгмийн Эгэх хариуцлага гэдэг нь иргэн, иргэний нийгмийн байгууллагын зүгээс иүүд болон иүүд бус замаар төрд хариуцлага тооцохыг хэлэх бөгөөд төр, хэвлэл мэдээлэл, хувийн хэвшил, хандивлагч байгууллагууд зэрэг оролцогч талуудын хариуцан тайлагнах, хариуцлага тооцох үйл явцтай холбогдох бүхий л үйл ажиллагааг хамааруулдаг.

Семинарын зорилт нь: Аймгийн хөгжилд иргэний оролцоог нэмэгдүүлэхэд оролцогч талуудад “Нийгмийн эгэх хариуцлага”-ийн тухай нэгдсэн ойлголттой болгох, эрүүл мэнд, боловсролын салбарын нийтлэг тулгамдсан асуудлыг тодорхойлон, шийдвэрлэх арга замыг боловсруулахад оршиж байгаа юм.



**МОНГОЛЫН БҮХ АРД ТҮМНИЙ СПОРТЫН ХИВ ИХ НААДАМ" НЭЭЛТЭЭ ХИЙЛЭЭ.**

Биеийн тамир, спортын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор Монголын Бүх Ард түмний спортын ХИВ их наадмыг 2016 онд орон даяар зохион байгуулах шийдвэрийг гаргасан. Энэхүү наадмын гол зорилго нь биеийн тамир, спортын хөгжлийг эрчимжүүлэх болон нийтийн биеийн тамир, их спортын хөгжлийн цаашдын чиг хандлагыг тодорхойлоход оршиж байгаа юм.



Монголын Бүх ард түмний спортын наадам 3-н үе шаттай зохион байгуулагдаж байгаа ба манай аймгийн хувьд 2-дахь шатны тэмцээн 2016 оны 05-р сарын 11-15-ны өдрүүдэд Спортын ордонд зохион байгуулагдлаа.

Увс аймгийн хувьд сагсан бөмбөг, волейбол, ширээний теннис, үндэсний бөх, үндэсний сур, шагайн харваа, хөнгөн атлетик, хөл бөмбөг, шатар, даам, цана гэсэн спортын 11-н төрлөөр аймаг, сумын нийт 41-н багийн 1000 гаруй тамирчид хурд, хүч, авъяас



чадвараа дайчлан өрсөлдлөө.

**“ЭХ БАРИГЧ, СУВИЛАГЧДЫН АЙМГИЙН ЗӨВЛӨГӨӨН” АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА.**

Аймгийн ЗДТГ-ын НХХ, ЭМГ, Нэгдсэн эмнэлэгээс хамтран “Эх баригч, сувилагчдын аймгийн зөвлөгөөн”-ийг энэ сарын 05-06-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Зөвлөгөөний зорилго нь эрүүл мэндийн салбарын 2012-2015 оны ололт сургамжийг дүгнэж, ЭМС-ын шинэчлэлд /2016-2020/ эмнэлэгийн мэргэжилтэн, ажилтны оролцоог нэмэгдүүлж, идэвхийг өрнүүлэхэд оршиж байгаа юм.

Зөвлөгөөнд төр, хувийн хэвшлийн эмнэлэгийн сувилагч, эх баригч, сумдын ЭМТ-үүдийн эх баригч, сувилагч нийт 300 гаруй эмч, сувилагчид оролцож байна.

Зөвлөгөөний эхний өдөр оролцогчдын дунд спортын тэмцээнүүд зохион

байгуулсан бол өнөөдөр аймгийн “ОЙРАД” ХДТ-т зөвлөгөөнийг нээж аймгийн ИТХ-ын дарга Ч.Чимэд, Засаг дарга Д.Цэндсүрэн, ЭМГ-ын дарга Д.Дулмаа болон бусад хүмүүс үг хэллээ.





### МАЛЧИН СУМ:

4 багийн хурал хийж ЗДТГ-ын албадын мэдээллийг эхний 5 сарын байдлаар танилцуулж, ИТХ-аас гарсан тогтоол шийдвэр, Сонгуулийн хуулийн сурталчилгаа хийх зэрэг ажлуудыг хийлээ. Багуудын хуралд давхардсан тоогоор 240 гаруй иргэн хамрагдаж мэдээлэл авч асуулт тавьж харуулт авсан байна.

Сумын төвийн бүх газрыг хянадаг эргэлддэг нэгдсэн камер байрлуулж ажиллсанаас гадна хороололд буй худалдаа үйлчилгээ эрхэлдэг 2

дэлгүүрийг камержуулах ажил хийлээ. Сумын цагдааг унаажуулж УАЗ469 машин хүлээлгэн өгөв.

### ӨЛГИЙ СУМ:

Тэргүүлэгчдийн хурлаар 2 зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулан баталлаа. ОНХС болон Сум хөгжүүлэх сангаар олгогдох зээлийн хэрэгжилтэнд хяналт тавих Мөн зээл олгох комиссын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах. Шагналд тодорхойлох тухай асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Мөн Өлгий суманд НҮБ аас тусламж



шаардлагатай 40 малчин өрхөд хүнсний багц тусламжийг үзүүлэв.

### ӨНДӨРХАНГАЙ СУМ:

1. Сургуулийн үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилт, гал тогоо бүхий газруудын үйл ажиллагаанд удирдамжийн дагуу хяналт хийж Үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа ААН-дийн үйл ажиллагаанд дутагдалтай илрүүлэн зөрчлийг арилгах хугацаатай үүрэг даалгавар өглөө.

2. Сумын ГХУСА33 ахлах сургуулийн ГХУС зөвлөлтэй хамтран "Сайн явах санааных" аяныг 04 дүгээр сарын 20-оос 05 дугаар сарын 20-ны хооронд зохион байгуулж 05 дугаар сарын 30-нд аяны хаалтын үйл ажиллагаа хийж үр дүнгээ тооцож ажиллалаа. Аяны хүрээнд 5 ажил төлөвлөж ахлах сургуулийн 6-12 дугаар ангийн бүх сурагчид, багш нарыг хамруулан зохион байгуулав.



### ХОВД СУМ

Ачит, Шивэр, Халиунбулаг багуудад Засаг даргын баталсан удирдамжийн дагуу 2016 оны 05 сарын 22-24-ний өдөрүүдэд ЗДТГ-ын хатмран 2013-2015 оны хооронд хийгдсэн ажлын тайлан тавих ажлыг зохион байгуулж иргэдэд эрүүл мэнд соёлын үйлчилгээ



үзүүлээ. Нэг цэгийн үйлчилгээгээр ИТХ, ЗДТГ, соёлын төв, Эрүүл мэндийн төв, ахлах сургууль, цэцэрлэг зэрэг байгууллагууд ажилаа тайлагнав. ИТХ-аас гарсан шийдвэр, хөтөлбөр тогтоол шийдвэрүүдийг танилцуулж ажиллаа тайлагналаа. УИХ-ын сонгуулийн тухай хуулиар иргэдэд мэдээлэл өглөө. Уг үйл ажиллагаанд Шивэр багт -35, Халиунбулаг багт 53, Ачит багт 52 иргэн хамрагдлаа.

Чанарын шаардлага хангахгүй 65 ширхэг Сангийн далай архийг мэргэжлийн хяналтын дүгнэлтийг үндэслэн устгалаа.

### ДАВСТ СУМ:

5-р сарын 31-нд Улаан загалмайн онцгой гишүүн, идэвхтэн дэмжигч иргэдийг хамруулан "Улаан загалмайн нэг өдөр"- арга хэмжээ зохион байгуулж, энэ үеэр хурал зөвлөлгөөнийг зохиож, Гар бөмбөгийн тэмцээнийг албан байгууллага, баг, иргэдийн дунд зохион явуулав.

УИХ болон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуулийг зохион байгуулах хэсгийн санал авах байрны ахлах, бусад зохион байгуулагчдыг томилж, сонгуулийн тухай хуулиар сургалт сурталчилгаа хийв.

Мэдээлэл технологийн даамал болон итгэмжлэгдсэн ажилтнуудыг сургалтанд хамруулж, сонгуулийн бэлтгэл ажлыг хангуулан ажиллаж байна.

Энэ үеэр Ю.Цэдэнбалын талбайд ЗДТГ-ын ажилчид хамтран мод тарьж, төв зам дагуух хог хаягдлыг цэвэрлэх ажил зохион байгуулав. 5-р сарын 23-нд ЗДТГ-



аас Хүүхдийн чуулган зохион байгуулав.

### Хаяг

Увс аймаг, Улаангом хот, 3-р баг  
Ө.Бадрахын гудамж,  
ЗДТГ-ын байр 210 тоот

Утас :70453627

Факс :70452214

И Мэйл:

info@khural.uv.gov.mn

Вэб сайт:

http://uvs.khural.mn/

Facebook:

Увс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал